

Н. Ишжамц  
Л. Хайсандай

### АУГАА ИХ ОКТЯБРИЙН СОЦИАЛИСТ ХУВЬСГАЛ БА ДОРНО ДАХИНЫ УЛС ТҮМЭН

Хүн төрөлхтний хөгжил дэвшил, дэлхий дахины хувьсгалт үйл явцад үндсэн эргэлт гаргаж шинэ эрин үеийн эхлэлтийг тавьсан аугаа их октябрийн социалист хувьсгал ялснаас хойш 61 жил өнгөрөв. Октябрийн социалист хувьсгалын 60 жилийн ойг бүх шударга хүн төрөлхтөн, зөвлөлтийн ард түмэн, социалист хамтын нөхөрлөлийн орнууд өргөнөөр ёслон тэмдэглэж өнгөрөөсөн билээ. 1911 оны 10-р сарын дараа дэлхий дахинд гарсан гайхамшигт үйл явдал, асар их өөрчлөлтийг эргэн санавал тэр бүхэн цөм их Октябрийн хувьсгалжуулагч үзэл санааны үр нөлөөтэй шууд холбоотой байна.

Октябрийн хувьсгал нь хөрөнгөтөн орнуудад пролетарийн социалист хувьсгал мандаж, ажилчны хөдөлгөөн өрнөн, колони хараат орнуудын үндэсний эрх чөлөөний тэмцэл бадрах өргөн бололцоо нөхцөлийг нээсэн байна.

1918 оны 1-р сард Финляндад ажилчны хувьсгал, наймдугаар сард Японд «тутаргын дайн» гэж алдаршсан хөдөлмөрчин олны хөдөлгөөн, 10-р сард Австри-Унгар, 11-р сард Германд хувьсгал гарсан нь чухамдаа ялгуусан Октябрийн шууд нөлөө байв.

1919 оны 3-р сард Унгарт, 4-р сард Баварид, 6-р сард Словакт пролетарийн хувьсгал ялж, зөвлөлт бүгд найрамдах улсууд байгуулагдаж байжээ.

Орос оронд Октябрийн хувьсгал ялж, дэлхий дээр ажилчин, тариачны анхны социалист улс үүсэн тогтсоноор империализмд колоничлогдон дарлагдсан улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн урьд хожид үзэгдээгүй хүчтэй өргөх болсон билээ. Энэ тухай МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал тэмдэглэж бичихдээ: «Колони, хараат орнууд дахь империализмын ноёрхлын үндсийг Октябрийн хувьсгал эвдэв. Дэлхий дээр нийгмийн нэг ч хувьсгал боолчлогдсон улс түмний хувь заяанд Октябрийн социалист хувьсгал шиг ингэж нөлөөлж байгаагүй юм»<sup>1</sup> гэжээ.

Их Октябрийн ялалт, түүний хувьсгалжуулагч үзэл санаа дорно дахины колони хараат орнуудын улс түмний эрх чөлөөний тэмцлийн өрнөлт хөгжилтөнд ихээхэн хүчтэй нөлөөлжээ. Октябрийн хувьсгалын ялалтын дараа Монгол, Хятад, Энэтхэг, Турк, Иран зэрэг дорнодахины олон оронд үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцэл урьд урьдаас улам далайцтай өрнөсөн юм.

1921 оны 7-р сард, Монголд ардын хувьсгал ялж, монголын ард түмэн өөрийн орны тусгаар тогтнолыг тунхагласан билээ. Мөн оны 2-р сард Афганистаны ард түмэн улс төрийн талаар биеэ дааж хөгжих замд орсон юм. 1923 оны 10-р сард Туркийн бүрэн эрхт бүгд найрамдах улс бий болсон байна.

1 Ю. Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал (нэгэн боть)  
УБ., 1976. 474-р тал

Дэлхийн хөдөлмөрчдийн суут жолоодогч В. И. Ленин колонийн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг интернациональч байр сууринаас үргэлж дэмжиж ирэхдээ дорно дахины ард түмний эрх чөлөөний тэмцлийг ихэд анхааран судалдаг байжээ. В. И. Ленин Октябрийн хувьсгалаас өмнөхөн пролетарийн хувьсгалыг колонийн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй нягт холбохын чухлыг зааж бичихдээ: «Бид тэргүүний орнуудын ухамсартай ажилчдыг бүх дарлагдсан орны ажилчид, тариачид, боолчуудтай туйлын нягт ойртуулан нэгтгэх үзлийг хэзээ ямагт баримталсаар ирсэн, баримталж ч байна, цаашдаа ч баримтлана...Бид бол Монгол, Перс, Энэтхэг, Египетчүүдтэй ойртон нийлэхийг бүх хүчээрээ чармайх бөгөөд эс тэгвэл Европ дахь социализм батгүй болох тул ингэхийг өөрийн үүрэг, өөрийн эрх ашиг гэж бид үзэж байна»<sup>2</sup> гэжээ.

Их Лениний үзэл санаа Октябрийн хувьсгалаар төрж мандсан зөвлөлт төрийн дотоод, гадаад бодлогын бүхий л үйл ажиллагаанд анх түрүүн биелэлээ олж эхлэсэн билээ. Бүр анхнаасаа зөвлөлт засаг империализмын колоничлолын бодлогыг эрс буруушааж, улс түмний тэгш эрх, бүрэн эрхт байдал, өөртөө засан тохирох эрхийг хүндэтгэх ёсыг олон улсын харилцаанд хэрэгжүүлж эхлэсэн явдал колони, хараат орнуудын ард түмэн, түүний дотор дорнодахины дарлагдсан улс түмний эрх чөлөөний хувьсгалт тэмцлийн өрнөлтөд бодитой дэмжлэг болсон юм.

В. И. Ленин үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хүчнүүдээс социализм лугаа холбоо тогтоохын интернационалч ач холбогдлыг цохон тэмдэглэхдээ: «Дорно дахины улс түмний энэхүү хувьсгалт хөдөлгөөн нь одоо үед олон улсын империализмын эсрэг тэмцэж байгаа манай Зөвлөлт Бүгд Найрамдах Улсын хувьсгалт тэмцэлтэй шууд холбоотой байснаар сая амжилттай хөгжин, зөв шийдвэрлэгдэж чадах нь аяндаа илэрхий юм»<sup>3</sup> гэжээ.

Лениний энэ сургаалын үнэн зөвийг 1921 оны Монгол ардын хувьсгал баталж өгөв. Зөвлөлт Оросын хувьсгалт ажилчин ангитай монголын малчин ард интернационалч хэлхээ холбоо тогтоосны ачаар ялсан манай хувьсгал нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг пролетарийн хувьсгалтай холбосоны яруу тод жишээ болсон юм.

Ийнхүү ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний интернационалч нягт холбоо л улс түмний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө тэмцлийг амжилтад хүргэж чаддагийг дэлхийн социалист хувьсгалын бүрэлдэхүүн хэсэг болсон монголын хувьсгал маргашгүй нотлов.

Их Октябрийн үзэл санааны нөлөө, Зөвлөлт оросын пролетари нарын тусламжийн ачаар ялсан ардын хувьсгалын үр дүнд Монгол орон дорно дахины колони, хараат орнуудын дотроос анх түрүүн эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж, ардчилал социализмын замд орсон юм. Энэ тухай МАХН ын программд заахдаа: «Ардын хувьсгал ялж колонийн дэглэмийг устган, тусгаар тогтносон төр улсыг байгуулсны үрээр Монгол орон дэлхийн империализмын системээс тасран салж, Октябрийн хувьсгалаар төрж мэндлэсэн шинэ ертөнц-социализмын ертөнцөд нийлж нэгдэв»<sup>4</sup> гэжээ.

Октябрийн үзэл санааны үр нөлөөгөөр тийнхүү Монголд ялан мандсан ардын хувьсгал нь манай ард түмэнд зол жаргал, хөгжил дэвшлийн замыг зааж, гэрэлт ирээдүй нээн өгсөн бөгөөд колони, хараат орнуудын хувьсгалын тухай марксист-ленинист сургаалын үнэн зөвийг батлан, боолчлогдсон бага буурай улс түмэн түүхэнд үүрэг холбогдол багатай, биеэ дааж хувьсгал хийх, бүтээлч үйл ажиллагаа явуулах чадваргүй хэмээн үзэж ирсэн хөрөнгөтний үзэл сурталчдын номлолд хүчтэй цохилт өгсөн юм. Үүгээрээ манай хувьсгал нь олон улсын ач холбогдолтой бөгөөд дор-

2 В. И. Ленин, Зохиолын 23-р боть, 62—63-р тал.

3 В. И. Ленин. Зохиолын 30-р боть, 135-р тал.

нодахины дарлагдсан улс түмний эрх чөлөөний тэмцэлд үлгэр жишээ болж, тэр тэмцлийн өрнөлт хөгжилтийн түүхэнд шинэ хуудас нээсэн юм.

Нөгөөтэйгүүр аугаа их Октябрийн хувьсгалын ачаар олон улсын шинэ маягийн харилцааны эх үүсвэрийг анх тавьсан Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцаа үүсэн тогтсон билээ. Бүрэн тэгш эрх, бие биеийг хүндэтгэх, харилцан туслах зарчим дээр тулгуурлан тогтоосон манай орнуудын харилцаа нь дорно дахины улс түмэнд их, бага улсуудын хоорондын жинхэнэ тэгш эрхтэй харилцааны үлгэр дууриал болсон билээ.

Хятад дахь үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцлийн 1917 оноос хойших бүх түүх нь хятадын ард түмэнд Октябрийн социалист их хувьсгалын үзүүлсэн асар их ач нөлөөтэй салшгүй холбоотой. Хятадын дэвшилт, ардчилсан үзэлтнүүд Октябрийн хувьсгалын ялалтыг талархан угтсан юм. Бээжинд болсон нэгэн цуглаан дээр хэлсэн үгэндээ нөхөр Ли Да-Чжао: «Оросын хувьсгал зөвхөн оросын төдийгүй, хорьдугаар зууны үеийн бүх хүн төрөлхтний ухамсарт өөрчлөлт гаргалаа»<sup>5</sup> гэж цохон тэмдэглэжээ.

Октябрийн хувьсгалын ачаар Хятадад марксизм-ленинизм нэвтрэн дэлгэрч, оросын хувьсгалын туршлага ба шинжлэх ухааны социализмын онол судлах бүлгэм дугуйлан байгуулагдсан нь Хятадад улс төрийн шинэ маягийн байгууллага-коммунист нам байгуулах нөхцөл бүрэлдүүлсэн бөгөөд тийм намыг Ли Да-Чжао, Чэнь Ду-сю нарын зэрэг хувьсгалчид үндэслэн байгуулсан юм. Түүхч Гын Мин бичихдээ: «Октябрийн социалист хувьсгал хятадын ард түмэнд асар их нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нөлөө хичнээн их хүчтэй, гүн гүнзгий байсан нь Октябрийн хувьсгал Хятадын Коммунист нам байгуулагдахад дөхөм үзүүлсэн явдлаар бүр ч тод илэрсэн юм»<sup>6</sup> гэж тэмдэглэсэн байдаг.

Хятадын нэрт ардчилсан хувьсгалч Сунь Ят-сен Октябрийн хувьсгалын ач нөлөөгөөр хятад улс үндсээ чөлөөлж, нийгмийг шинэчлэн өөрчлөхөд чиглэгдсэн улс төрийн үйл ажиллагаагаа идэвхжүүлсэн юм. Сунь Ят-сений зэрэг хятадын хувьсгалчид өөрийн орны хувьд цоо шинэ бодлого тунхаглаж, урьд өмнө Хаант Оросын байгуулсан бүх нууц гэрээ ха лэлцээр, эрх дархаас татгалзсан Зөвлөлт засгийн газартай нягт харилцаа холбоо тогтоож бэхжүүлэх, хятад-зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааны төлөө тууштай тэмцэж байлаа.

«Оросын хувьсгалын зорилго Хятадын хувьсгалын зорилготой нийцэж байгаагийн нэг адил Хятадын хувьсгалын зорилго ч оросын хувьсгалын зорилготой нийцэж байна. Тийм ч учраас Хятад, Орос хоёр нэг замаар явж байна»<sup>7</sup> гэж Сунь Ят-сен бичиж байв.

Чухамдаа хятадын 1925—1927 оны хувьсгал бол хятадын ард түмний хувь заяанд Октябрийн үзүүлсэн нөлөөний үргэлжлэл үр дүн байсан юм. Зөвлөлт Холбоот Улсын тусламж дэмжлэгтэйгээр өрнөсөн энэ хувьсгал Хятад дахь империализм, милитарист хүчний ноёрхлыг сулруулж, хятадын нийгмийн улс-төрийн хүчний харьцааг нааштайгаар өөрчилж байв. Гэтэл 1927 оны 4-р сард Чан Кай-ши харгис эргэлт хийж, ЗХУ-тай найрамдалт харилцааг таслан, Хятадын Коммунист намтай хамтран ажиллахаас татгалзсан нь Сунь Яг-сений улс төрийн программыг амьдралд тууштай хэрэгжүүлэх явдалд саад учруулсан юм. Гэлээ ч гэсэн хувьсгал-

4 МАХН-ын программ. УБ., 1966. 7-р тал.

5 Ли Да-Чжао. Хэлсэн үг, өгүүллийн түүвэр. Москва, 1965.

6 Пын Мин. Хятад-Зөвлөлтийн найрамдлын түүх. Москва, 1959 он, 91-92-р тал (оросоор)

7 Сунь Ят-сен. Түүвэр зохиол, Москва, 1964 он, 527-р тал (оросоор).

лын ачаар хятад орон зогсонги байдлаас гарсан бөгөөд эрх чөлөөт, бүрэн эрхт улс байгуулах замаар ахин давших хөдөлгөөнийг нь ямар ч харгис хүч саатуулан барьж чадахгүй болсон юм.

Дэлхийн II дайны дараагаар империализм, колоницлолын эсрэг дорно дахины улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн улам хүчтэй өрнөв. Аугаа их Октябрийн эх орон-ЗХУ дайны бүхий л хүнд хүчрийг үүрч, фашизм ба милитаризмын эсрэг энх тайван, эрх чөлөөг эрхэмлэгч бүх хүчний хамт баатарлагаар тэмцэн, түүхэн ялалт байгуулж, өрнө, дорнын улс түмнийг боолчлол сүйрлийн аюулаас аварсны дүнд дэлхийн социалист систем үүсч тогтсон билээ. Энэ нь улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний далайц, шинж чанарт шийдвэрлэх нөлөө үзүүлэв.

Социалист орнууд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нэн идэвхтэй дэмжиж, түүнд улс төр, дипломат, эдийн засаг зэрэг бүх талын тусламж дэмжлэг үзүүлэх явдал улам өсөн нэмэгдсэн нь империалист колоницлолын эсрэг ялгуусан их тэмцэл өрнүүлэхэд ихээхэн зохистой сайхан нөхцөл бүрдүүлсэн юм.

Октябрийн хувьсгалын ялалтаар эхлэн эрчимтэй өрнөсөн дэлхийн хувьсгалт үйл явц, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хүчирхэг давшилтын үр дүнд империализмын колонийн систем бүхэлдээ задран унав. Энэ нь «...түүхэн ач холбогдлоороо дэлхийн социалист систем үүсч байгуулагдсан явдлын дараа орох үзэгдэл болов»<sup>5</sup> Тэр үеэс үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн шинэ шатанд гарав. Үндэсний олон арван шинэ улс үүсэн тогтож, олон улсын үйл явдалд чухал хүч болж хувирлаа. Энэхүү түүхэн үйл явдлыг их Ленин шинжлэх ухааны үүднээс угтан харж тодорхойлохдоо: «Орчин үеийн хувьсгал дахь Дорнод дахины сэргэлтийн үеийн дараа Дорно дахины бүх ард түмэн зөвхөн баяжуулагч газар байхаа больж, бүх дэлхийн хувь заяаг шийдвэрлэхэд оролцох үе эхлэж байна»<sup>6</sup> гэжээ.

Азийн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинэ өрнөлт, түүний түүхэн амжилт нь дэлхийн II дайны дараа тус тивд бий болсон чанарын хувьд цоо шинэ нөхцөл байдал лугаа шууд холбоотой.

ЗХУ-ын улаан арми холбоотон гүрнүүдийн хамт БНМАУ-ын ардын хувьсгалт цэргийн оролцоотойгоор японы империализмыг бут цохисон нь Ази ба нийт дорно дахины хүчний харьцаа, олон улсын харилцааны цар хүрээнд гүн гүнзгий өөрчлөлт оруулсан юм. Тухайлбал, 1945 оны 8-р сард Зөвлөлтийн улаан арми БНМАУ-ын ардын армийн ангиудтай хамтран империалист Японы хуурай замын цэргийн шигшмэл бүлэглэл-Кван туны армийг бут цохин Хятадын нутаг дэвсгэр дээрх харийн булаан эзлэгчдийн гол түшиц Манж-Гог устгасан юм. Хятадын эдийн засгийн хувьд хамгийн хөгжингүй нутаг байсан 40 сая гаруй хүн амтай Зүүн хойт хятад (Манжуур) тийнхүү чөлөөлөгдөж улс төрийн шинэ төв, хятадын хувьсгалын найдвартай бааз болж хувирсан юм. Энэ нь наашдаа Хятадад ардын хувьсгал ялж, хятадын ард түмэн үндэсний ба нийгмийн дарлалаас чөлөөлөгдөн эрх чөлөөлгөө олж хөгжих урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд үнэлж баршгүй чухал ач холбогдолтой үйл явдал байв.

1949 онд Хятадын ард түмэн ЗХУ-ын бүх талын сэтгэл харамгүй интернационалч тусламж дэмжлэгт түшиглэн коммунист намынхаа удирдлагаар гадаад, дотоодын дарлан мөлжигчлийн эсрэг баатарлаг тэмцэл хийж, ардын хувьсгалыг ялалтанд хүргэн, БНХАУ-ыг байгуулсан билээ.

5 1960 онд Москва хотноо болсон коммунист, ажилчны намуудын төлөөлөгчдийн зөвлөлгөөнөөс гаргасан мэдэгдэл, УБ, 1961, 47-р тал

6 В. И. Ленин. Зохиолын 30-р боть, 144-р тал

Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдахад үүнийг тусгаар тогтносон, бүрэн эрхт улс гэж ЗХУ болон социалист бусад орон тэр даруйд зөвшөөрөн хүлээж, дипломат харилцаа тогтоон, улс ардын аж ахуйгаа сэргээн босгох, тус оронд социализмын эдийн засгийн бааз суурийг тавих, социалист байгуулалтын анхны томоохон амжилт олоход ах дүү ёсны асар их тусламж дэмжлэг үзүүлсэн билээ. Гэтэл Хятадын Коммунист намын удирдлагыг 1935 оны үест булаан авсан, хувьсгалт лоозонгоор халхавч хийж үндсэрхэг бодлого явуулагч, жижиг хөрөнгөтний адал балмад явдалтан Мао Цзэдун тэргүүтэй их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзэлт Бээжингийн удирдагчид тавиад оны эцэс, жараад оны эхнээс эхлэн Хятадын ардын хувьсгал, БНХАУ-ын социалист байгуулалтанд ЗХУ зэрэг социалист орнуудын тусламжийг ор тас үгүйсгэн, зөвхөн «өөрийн хүчинд тулгуурлах» нэрийдлээр дэлхийн социалист системээс зожигрон салж, империализм ба харгис хүчинтэй эвсэн хорших замд орсон нь БНХАУ-ын эдийн засаг, соёлын хөгжлийн хурдцыг бууруулж, тус орны социализмын байгуулалтын ололт амжилтыг үрэн таран хийж, хятадын ард түмэнд гашуун зовлон учруулав. Ялангуяа Хятад орныг цэрэгжүүлж, даян дэлхийд дайны бодлого явуулж байгаа явдал БНХАУ-ын өөрийн нь болон энхийг эрхэмлэгч бүх улс түмний эрх ашиг, ардчилал социализмын үйл хэрэгт ноцтой харшилж байна.

Зөвлөлтийн улаан арми 1945 онд Солонгосыг чөлөөлсөн нь тус орны умард хэсэгт ардын ардчилсан хувьсгал ялах таатай нөхцөл бүрэлдүүлсэн юм. «...Зөвлөлтийн арми японы империализмын дарлалаас Солонгосыг шууд чөлөөлсөн нь Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс байгуулагдахын, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ч ялан мандахын нэг чухал нөхцөл болж өгсөн юм. Зөвлөлтийн арми Солонгосыг чөлөөлөөгүй бол Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс ч үүсэн тогтохгүй, манай үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ч ялан мандахгүй байсан юм. Тийнхүү ЗХУ дэлхийн II дайнд ялсан нь Солонгосын ард түмний түүхэнд шинэ хуудас нээсэн билээ»<sup>7</sup> гэж нөхөр Ким Ир-сен тэмдэглэн хэлжээ.

Дэлхийн II дайн, милитаризмын эсрэг тэмцэлд ЗХУ ялсан явдал 1945 оны 8-р сард Вьетнамын ардын хувьсгал мандахад эрхэм чухал тус дөхөм болсон байна. Олон улсын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Хо Ши-миний онцлон тэмдэглэсэнчлэн, гитлерийн фашизм, японы милитаризмыг Зөвлөлтийн яруу алдарт арми бутохисон нь Вьетнам оронд бүх нийтийн бослого ялж, 1945 оны 9-р сарын 2-нд Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улс байгуулагдахад ихээхэн тус дөхөм болжээ.

Вьетамын баатарлаг ард түмэн Америкийн империализмын түрэмгийллийг бутцохиж, улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн, нэгдсэн Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсыг байгуулахад ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын тууштай дэмжлэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ нь Энэтхэг-Хятадын бусад улс түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэл амжилт олоход ихэд дөхөм боллоо.

Их Октябрийн үзэл санаа, Дэлхийн I дайнд ЗХУ, ардчилал, энх тайвны хүчин ялсны ач нөлөө ба социалист орнуудын ард түмний чөлөөгчлөгч хувьсгалт тэмцлийн үлгэр жишээ, дэмжлэг тусламжтайгаар Энэтхэг, Индонез, Бирм, Филиппин, Малайзын ард түмэн үндэсний хувьсгалт тэмцэлд босон эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсан юм.

Үндэсний эрх чөлөөний хүчнүүдээс ЗХУ, Дэлхийн социалист систем, олон улсын коммунист хөдөлгөөнтэй тогтоосон империализмын эсрэг хол-

7 Ким Ир-сен. Аугаа их Октябрийн үзэл санааны ялалт, Москва 1962. 298-р тал (оросоор).

боо харилцаа нь ямар их хүчирхэг үр нөлөөтэйг дайнаас хойшхи хөгжлийн бүх үйл явц илтгэн харуулж байна.

Үндэсний шинэ тулгар улсууд одоо үед социалист хамтын нөхөрлөлийн эв санааны дэмжлэг, интернационалч тусламжид тулгуурлан улс төр, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн бүхий л салбарт дэвшилт шинэчлэлт, үндсэн өөрчлөлт хийхийн төлөө амжилттай тэмцэж байна.

Орчин үеийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэг чухал тал бол уг хөдөлгөөний нийгмийн агуулга гүнзгийрч империализмын төдийгүй капитализмын эсрэг чиглэсэн ангийнгийн шинж чанартай болж байгаа явдал юм. «Дэлхий дахины хувьсгалын ирээдүйн шийдвэрлэх тулалдаанд, эхлээд үндэсний эрх чөлөө олоход чиглэсэн Дэлхийн бөмбөрцгийн хүн амын олонхийн хөдөлгөөн гараад дараа нь капитализм, империализмын эсрэг чиглэнэ»<sup>8</sup> гэж В. И. Лениний урьдчилан зөгнөж хэлсэн суут мэргэн санаа өнөөдөр бид бүхний нүдний өмнө бодитой хэрэгжин биелж байна. Орчин үеийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үндсэн агуулга нь империализм, шинэ колоничлолын эсрэг, үндэснийхээ тусгаар тогтнолыг хамгаалах, олон улсын хөдөлмөрийн хуваарьт тэгш эрхтэй болохын төлөө, байгалийнхаа нөөц баялгийг бүрэн эрхтэй эзэмшихийн төлөө тэмцэл болж байна.<sup>9</sup> Энэ тэмцэл улам бүр нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцлийн шинжтэй болж байна. Ази, Африкийн нилээд улс орон социализм байгуулах хэтийн төлөв нээгч социалист чиг баримжаа, капиталист биш хөгжлийн замд орж хөгжин байна. Тэдгээр орон тийнхүү капиталист биш замаар хөгжих зорилт тавьж байгаа нь нэн түрүүнд эдийн засгийн талаар биеэ даах эрх сонирхол, аж ахуй соёлын олон үеийн хоцрогдлыг арилгах, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх, хөдөлмөрчдийг нийгмийн талаар чөлөөлөх зэрэг нийгмийн хөгжлийн зүй тогтол, бодит шаардлагатай шууд холбоотой юм.

Социалист чиг баримжааны замд ороод байгаа улс түмэн ЗХУ, социалист ертөнцийн тусламж дэмжлэгт түшиглэн капиталист биш хөгжлийн зорилтоо амжилттай хэрэгжүүлж чадахыг түүх нэгэнт нотлосон юм. Нөхөр Ю.Цэдэнбалын өгүүлсэнчлэн эдийн засгийн талаар туйлын хоцрогдсон орон ч гэсэн марксист-ленинист намаар удирдуулж, олон улсын ажилчны хөдөлгөөнөөр дэмжүүлэх юм бол үндэсний тусгаар тогтнолоо тэмцэн олж бэхжүүлээд, хөрөнгөтний биш хөгжлийн замаар, ардчилал социализмын замаар итгэлтэй замнаж чадахыг улс үндсээ сэргээж, Бүгд найрамдах социалист төрөө байгуулсан Монголын бүх туршлага харуулж байна.<sup>10</sup>

Монголын ард түмэн ардын хувьсгалыг ялуулж, эрх чөлөөг олсон тэр цагаас эдүгээ хүртэл Октябрийн хувьсгалын үзэл санааг чин бат баримтлан, даян дэлхийн хөдөлмөрчид, бага буурай улс түмний өмөг түшиг болсон Зөвлөлт орноос бүх талын тусламж дэмжлэгийг авч, шинэ амьдралаа цогцлон байгуулж ирэв. Аугаа их Октябрийн социалист хувьсгалын 60 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолд онцлон тэмдэглэсэнчлэн их Октябрийн үзэл санааны нөлөө, ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжийн ачаар монгол орон олон зуун жилийн хоцрогдмол байдал, өнгөрсөн үеийн колонийн болон феодалын хүнд бэрх үлдэгдлийг харьцангуй богино хугацаанд арилгаж, феодализмаас

8 В. И. Ленин. Зохиолын 29-р боть. 392-р тал

9 Ю. Цэдэнбал, МАХН-ын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. УБ., 1976. 16-р тал.

10 Ю.Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал, УБ., 1976. 235-р тал

социализмд шилжих түүхэн үсрэлт хийж, өрнөн хөгжсөн эдийн засаг, цэцэглэн мандсан орчин үеийн соёлтой социалист орон болсон билээ.<sup>11</sup> Үүнээс үзэхэд үндэсний шинэ тулгар улсуудын цаашдын дэвшил хөгжил, тухайлбал капиталист биш хөгжлийн замаар амжилттай замнан хөгжихөд ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой өргөн дэлгэр харилцаа, хамтын ажиллагаа тогтоож өрнүүлэх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой. Империалист мөлжлөгөөс бүрмөсөн ангижран хөгжих хууль ёсны эрмэлзлэлээ хэрэгжүүлэхийн төлөө, хувь заяагаа өөрөө шийдэх эрхийн төлөө тэмцэхэд нь шинэ тулгар хөгжиж байгаа орнуудад ЗХУ, социалист бусад улс бүх талын дэмжлэг үзүүлж байна. ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд хөгжиж буй орнуудад 3000 орчим барилга байгууламж барьж, тэн хагас нь ашиглалтанд ороод байна. Хөгжиж байгаа орнуудад үзүүлж буй ах дүү социалист орнуудын тусламж капиталист орнуудын зээллэг сэлтийг бодвол улс төр, эдийн засгийн ямар ч болзол нөхцөл тавиагүй, харилцан ашигтай, бүрэн тэгш эрхийн зарчим дээр үндэслэсэн хийгээд тэдгээр орныг аж үйлдвэржүүлэх, эдийн засгийг нь түргэн хурдацтай хөгжүүлэхэд чиглэж байгаагаараа онцлог юм. Түүнчлэн ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд шинэ тулгар хөгжиж буй эдгээр оронд удаан хугацааны хөнгөлөлттэй зээл олгож байгаа бөгөөд түүний нийт хэмжээ эдүгээ 11 миллиард гаруй рубль болжээ. Бас ах дүү орнуудад «гуравдагч ертөнцийн» улсуудаас олон арван мянган мэргэжилтэн, оюутан залуус суралцаж бэлтгэгдсээр байгаа ба жил дутам тэдгээрийн тоо улам нэмэгдэж байна.

Энэ бүхний дүнд Ази, Африкийн орнуудын улс түмэн үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө, эдийн засгийн биеэ даасан байдлын төлөө, империализм, шинэ колоничлолын эсрэг тэмцэлдээ их амжилт олсоор байна. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний бүх зорилт хараахан бүрэн төгс шийдвэрлэгдээгүй нь мэдээж боловч түүний цаашдын амжилт ялалтын төлөв баримжаа тодорхой байна.

Империалист харгис хүчний зүгээс улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхэн ололтыг устгах, эрчимтэй явцыг нь саатуулж сарниулах гэж оролдохдоо янз бүрийн арга явууллага хийж байна. Чөлөөлөх хөдөлгөөний эсрэг хандсан империализмын бодлого нь нийгмийн амьдралын бүх салбарыг хамарч байгаа юм. Үүнд, улс төрийн талаар империа листууд нь хөгжиж байгаа орнууд, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэлхийн социалист системийн нөлөөнөөс таслан салгах, хувьсгалт хөдөлгөөний эгнээний нэгдлийг бутарган сарниулахыг оролдож харгис хүчнүүдийг зэвсэглэн санхүүжүүлэх, Зэвсэгт түрэмгийллийг өөгшүүлэх, төрийн харгис эргэлт хийх хүртэл арга хэрэглэж байна. Эдийн засгийн талаар гэвэл империалистууд капитал гаргалт, гадаад худалдаа, валютын гүйлгээ, үнийн бодлогын арга хэрэгсэл бүхнээ ашиглан, улаанцайм хавчин хяхах, эсвэл аар саар буулт хийх, «тусламж», «Зээл» өгөх нэрийдлээр хөгжиж байгаа орнуудыг тонон дээрэмдэж, дэлхийн капитализмын хүрээнд, өөрсдийн эрхшээл хараанд байлгахыг гол болгож байна. Үзэл суртлын салбарт империалистууд гүтгэн гүжирдэх, хутган үймүүлэх, хууран мэхлэх элдэв аргаар суртал нэвтрүүлэг явуулж, түүндээ коммунизмын эсрэг, зөвлөлтийн эсрэг төрөл бүрийн номлол гарган дэлгэрүүлэхийг оролдож практик үйл ажиллагаандаа тэд гуравдагч ертөнцийн улс түмнийг капиталист системийн нөлөний хүрээнд хүчээр оруулан барьж, урьдын ноёрхлоо сэргээж үргэлжлүүлэхийн тулд Африк, Ази, Латин Америкийн улс орнуудын дотоод хэрэгт ичгүүр сонжуургүй хөндлөнгөөс оролцож байна.

АНУ тэргүүтэй НАТО-гийн орнууд, Африк дахь Заир, Ангол, Эфиопи зэрэг орнуудад цэргийн түрэмгийлэл хийж, Ази, Африк, Латин Америкийн зарим орны аль харгис засгийн дэглэмүүдийг тэтгэн дэмжиж ялангуяа социалист чиг баримжааг шилж аваад капиталист биш хөгжмийн замд орж хөгжиж байгаа орнуудыг тэд онцгой дайсагнаж байна.

Энэ бүхний эцсийн зорилго нь социализм ба үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний холбоо хэлхээг таслан, түүний империализмын эсрэг шинж чанарыг алдагдуулан, шинэ колониололын бодлогоо хэрэгжүүлэх мөн. Ийм нөхцөлд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний амжилт олох баталгаа болсон хувьсгалт бүх хүчний үйл ажиллагааны нэгдлийг бэхжүүлэх, империализмын эсрэг нэгдмэл хүчээр тэмцэх явдал зайлшгүй шаардлагатай байна. Гэтэл их Октябрийн хувьсгалын нөлөөгөөр ялсан Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн ололтыг хөсөрдүүлж, түүний зорилт, үзэл санаанаас ухарсан өнөөгийн хятадын эрх баригчдын явуулж буй социализмын эсрэг, задлан бутаргах, дэлхийн дайн дэгдээх гэсэн түрэмгий харгис бодлого, практик үйл ажиллагаа нь улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний жинхэнэ эрх ашигт эрс харшилж байна. Бээжингийн маоист удирдлага империализмын хамгийн харгис хүчнүүдтэй эвсэж, Африкийн улс түмний эсрэг тэдний балмад түрэмгийллийг илт дэмжиж, улмаар социалист Вьетнамын эсрэг Кампучийг түрэмгий дайнд түлхэн оруулж, Вьетнам дахь хятад цагаачин нарыг тус улсын нам, Төр, ард түмний эсрэг өдөөн хатгаж, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцож байгаа явдал маогийнхан социализм, үндэсний эрх чөлөө, энх тайвны үйл хэргээс хэдийнээ урван тэрслэснийг дахин нотолж, даян дэлхийн улс түмний сэтгэлийг түгшээн, түүний шударга бөгөөд зоримог шийдэмгий эсэргүүцэлтэй зүй ёсоор тулгарч байна.

Бээжингийнхэн империализмын хамгийн харгис дэглэмүүдийг дэмжиж, түрэмгий хүчнүүдтэй сүлбэлдэж, социализм ба үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг бодлого баримталж байгаагаараа империализмын бэлтгэл хүч, хань хамсаатан болсон юм. Тийм учраас маоизмын эсрэг тэмцэл бол империализмын болон харгис хүчнийг эсэргүүцсэн улс түмний тэмцлийн салшгүй хэсэг мөн<sup>12</sup> гэж манай намын XVII их хурлаас заан тэмдэглэсэн билээ.

Хөгжиж байгаа орнуудын ард түмэн, түүний дотор эрх чөлөө, энхийг эрхэмлэгч дорно дахины улс түмэн империализм ба түүнтэй холбоотой харгис хүчний эсрэг нэн шийдвэртэй тэмцэж, социалист хамтын нөхөрлөлтэй хэлхээ холбоогоо улам бэхжүүлж байна.

Дорнодахины улс түмний туулж өнгөрүүлсэн түүхэн замыг эргэж харахад тэд хэзээ ч Октябрийн хувьсгалын ялалтаас хойших үе шиг тийм харьцангуй ахар богино хугацаанд нийгэм-улс төрийн ийм их шинэчлэлт өөрчлөлт хийж, тус тусын улс орны хувь заяаг амжилттай шийдвэрлэн, олон улсын давцан дээр ингэж идэвхтэй нөлөөлөлтэй гарч байгаагүй байна. Хэдэн зуун жилийн турш колониололын дарлалд нэрвэгдэн, эрх чөлөөгүй, харанхуй бүдүүлэг хоцрогдож байсан Ази, Африк, Латин Америкийн улс түмэн, дорно зүгийн ард түмэн ЗХУ зэрэг социалист хамтын нөхөрлөлийн орнуудын тусламж дэмжлэгийг хүлээж, үндэсний эрх чөлөөгөө байлдан олоод нийгмийн дэвшил хөгжлийн замд амжилттай гарсан нь эцсийн эцэст аугаа их Октябрийн социалист хувьсгалын үр нөлөө, түүний ялгуусан их үйл хэргийн бүтээлч үргэлжлэл, марксизм-ленинизмын сургаалын цаашдын хэрэгжин биелэлт мөн.

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нөхөр Л. И. Брежнев аугаа их

12 «Үнэн». 1976—6—15.

Октябрийн социалист хувьсгалын яруу алдарт 60 жилийн ойд зориулж, Москва хотноо Кремлийн ордонд хийсэн ЗХУКН-ын Төв Хороо, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөл, ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн хамтарсан баярын хурал дээр тавьсан илтгэлийнхээ дотор улс түмний чөлөөлөх хөдөлгөөнд их Октябрийн үзүүлсэн нөлөө, дорнодахины орнуудын ард түмний өнөгийн амьдрал хөгжил, цаашдын ирээдүй төлөвийн тухай дүгнэн хэлэхдээ: «Чухамхүү Октябрийн ялалт нь монголын ард түмний оюун санааг жинхэнэ ёсоор сэргээж, империализмын дарлалаас чөлөөлөгдөхийн төлөө тэмцэлдээ асар их амжилт олоход нь тэдэнд тусалсан билээ ...өөрсдийн зорилго, амьдралд эзлэх байр сууриа ухамсарласан сая сая хөдөлмөрчдийн хүсэл зориг бол үндэсний тусгаар тогтнолыг бэхжүүлэх, мөлжлөг дар лалгүй нийгмийн байгууллын эцсийн ялалтыг хангах найдвартай баталгаа мөн ...улс түмнийг чөлөөлөх үйл хэрэг ялагдашгүй бөгөөд ирээдүйтэй юм. Октябрийн бадраасан гэрэл дэлхийн түүхийн энэ фронт дээр ч бүдгэрч бөхөхгүй ээ»<sup>13</sup> гэж дурдсан нь түмэн зөв гэдэгт бид бүхэн итгэл төгс байна.

**Н. Ишжамц, Л. Хайсандай**

## ОКТЯБРЬСКАЯ РЕВОЛЮЦИЯ И НАРОДЫ ВОСТОКА

### Резюме

Авторы статьи, подчеркивая всемирно-историческое значение Великой Октябрьской социалистической революции, показывают на примере Монголии, Китая и других стран революционизирующее воздействие Октября на страны Востока.

Под непосредственным влиянием Октябрьской революции сразу же после Октября вспыхнули пролетарские революции в Германии, Венгрии, Словакии; рабочий класс и трудящиеся массы стран капитала поднялись на новую революционную борьбу, начался новый этап антиимпериалистического, антиколониального, национально-освободительного движения угнетенных народов Азии, Африки, Латинской Америки, которые нашли в лице В.И.Ленина, русских большевиков и Советской России реальную поддержку.

Победа народной революции 1921 г. в Монголии, претворение в жизнь ленинской идеи некапиталистического пути развития и построение социализма в ранее отсталой, кочевой стране неопровержимо доказали правоту и универсальное значение учения марксизма-ленинизма.

Победа Великой Октябрьской революции, в результате которой образовалось первое в мире социалистическое государство, имела громадное значение для освободительной революционной борьбы китайского народа.

Разгром во Второй мировой войне советскими войсками Квантунской армии в огромной мере облегчил успехи китайской народно-освободительной армии и последующую победу народной революции в Китае.

Победа Советского Союза над гитлеровским фашизмом и японским милитаризмом означала огромную помощь также и другим народам Вос

тока в освобождении от колониального гнета империализма и развертывании революционной борьбы. Многие народы Востока сбросили колониальное иго. В 60-х годах стал совершившимся фактом крах колониальной системы империализма.

Ряд стран Азии, Африки и Латинской Америки, решительно отвергая капиталистический путь развития, избрал уже социалистическую ориентацию и встал на путь некапиталистического развития. При поддержке, с помощью и в тесном сотрудничестве с СССР и другими странами социалистического содружества они добились в своем развитии значительных успехов.

Во всем этом огромную роль сыграли революционизирующее влияние Великого Октября, вдохновляющий пример Советского Союза и других социалистических стран. Советский Союз оказал и оказывает неоценимую помощь народам Востока в деле национального освобождения и социального прогресса, что особо подчеркивается в статье.

В статье анализируется неоколониалистская политика империалистических стран, их агрессия против народов Африки, Азии и Латинской Америки.

Большое внимание авторы обращают на разоблачение и критику маоизма по национально-колониальным вопросам. Они раскрывают антисоциалистический, антисоветский, великодержавно-шовинистический характер политики пекинского руководства и решительно осуждают его вмешательство во внутренние дела стран Азии, Африки и Латинской Америки.

В заключение авторы отмечают, что народы развивающихся стран, особенно те страны, которые избрали социалистическую ориентацию, неуклонно усиливая борьбу против империализма, неоколониализма и реакции, еще более укрепляют свое сотрудничество со странами социалистического содружества, что дает им возможность довести до конца дело национального освобождения, социального развития и приобрести настоящую независимость, свободу и счастье.